

БАТЛАВ
СУХБААТАР ДЭВШИЛ ОНЦААТУГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АМГАЛАН
2024 оны 03 дугаар сарын 25-ний өдөр

**АВТОМАТ ХУДГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /УЛААНБААТАР, СУХБААТАР
ДҮҮРЭГ/ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Байршил: Сүхбаатар дүүрэг 1-20 дугаар хороо

Ажлын цар хүрээ: Ундны Усны худаг автоматжуулалт

| Д/д | Тоног, төхөөрөмж | Техникийн тодорхойлолт |
|------------------------------------|----------------------------------|---|
| Хэрэглэгч | | |
| 1 | Карт уншигч | NFC карт уншигч ISO14443A, 13.56MHz |
| 2 | Ус нээх, хаах товчлууур | Монгол улсын цаг уурын нөхцөлд тохирсон бат бөх, IP 67 үнэлгээг хангасан, халуун, хүйтэнд тэсвэртэй, хэрэглэхэд хялбар байх. |
| 3 | Ерөнхий мэдээлэл харуулах дэлгэц | Хэрэглэгчийн картын дугаар, үлдэгдэл, авч буй усны хэмжээг заасан, өдөр шөнө саадгүй харагдах, хялбар эвдэрч хэмхэрхээргүй бат бөх, ус чийгэнд тэсвэртэй дэлгэц байна. |
| Биет аюулгүй байдлын хяналт | | |
| 1 | Утаа мэдрэгч | Өөр дээрээ баттерейтай, 85 дБ чанга дохио өгөх чадалтай, wireless холболттой, бодит хугацаанд мэдээлэл дамжуулах боломжтой байх, өөрийгөө шалгах функцтэй. |
| 2 | Температур мэдрэгч | Дижитал мэдрэгч байна, температурын мэдээллийг худгийн автоматжуулалтын процессор тогтмол хянаж байх. Температурын мэдээллийг төв серверт бодит хугацаанд тогтмол шинэчилж байх |
| 3 | Чийгшил мэдрэгч | Дижитал мэдрэгч байна, чийгшлийн мэдээллийг худгийн автоматжуулалтын процессор тогтмол хянаж байх. Температурын мэдээллийг төв серверт бодит хугацаанд тогтмол шинэчилж байх |
| 4 | Камерын хяналт | Бүх худгууд дотор хяналтын нэг, гадна хяналтын нэг камертай. Камерууд нэгдсэн нэг хяналтын системд холбогдсон байна. Диспетчер шаардлагатай тохиолдолд дурын худгийн бичлэгийг ухраан үздэг байх. |

| Автоматжуулалт | | |
|-----------------------|------------------------------------|--|
| 1 | Нэгдсэн хяналтын сервер | Unix-Like үйлдлийн системтэй, бусад худгийн төхөөрөмжтэй VLAN сүлжээгээр холбогдсон, мэдээллийн аюулгүй байдлыг найдвартай хангасан байна. |
| 2 | Серверийн програм хангамж | Веб-д суурилсан үйл явдалд тулгуурласан бодит цаг хугацааны /event driven realtime web based app/ програм хангамж байна. Диспитчер сүлжээнд холбогдсон худгуудын орчны температур, чийгшилийн мэдээлэл, өдөр, сар, жилийн борлуулалтын тайланг авах боломжтой, нөөцлүүрийн савны үлдэгдлийг хувиар харах боломжтой байх. Мэдээлийн аюулгүй байдлыг өндөр зэргээр хангасан байна. |
| 3 | Худгийн процессорын автоматжуулалт | Unix-Like үйлдлийн системтэй, бусад худгийн төхөөрөмжтэй VLAN сүлжээгээр холбогдсон, мэдээллийн аюулгүй байдлыг найдвартай хангасан байна. Мэдрэгчүүдээс бодит цаг хугацаанд мэдээлэл авдаг байх. Авсан мэдээллийг сервер рүү илгээдэг байх. Мэдээлийн аюулгүй байдлыг өндөр зэргээр хангасан байна. |
| Сүлжээ | | |
| 1 | Интернэт | 4G, LTE gateway байна, дор хаяж 4 порттой. |
| 2 | Дотоод сүлжээ | VLAN сүлжээнд холбогдсон байна |

Захиалагчийн хяналт:

- Тоног төхөөрөмжийн чанар, тоо хэмжээ, стандартын дагуу хугацаандаа нийлүүлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих
- Тоног төхөөрөмж нь чанартай гарал үүслийн гэрчилгээтэй байх

Нийлүүлэгч байгууллага:

- Нийлүүлэгч байгууллага нь тоног төхөөрөмжийн бүрэн ажиллагааг хангахын тулд бараанд зайлшгүй шаардлагатай бүх нэмэлт ба дагалдах хэрэгслүүдийг хамтад нь санал болгох
- Нийлүүлэгч байгууллага нь тоо хэмжээний дагуу чанартай тоног төхөөрөмжийг суурилуулан гэрээний хугацаанд багтаан нийлүүлэх
- Тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй гэмтэл, элэгдэл хорогдлын зардлыг нийлүүлэгч байгууллага өөрөө хариуцна.

- Нийлүүлэгч байгууллага нь баталгааны хугацааг худалдан авагчид гаргаж өгнө.

Баталгаат хугацаа нь хүлээн авсан өдрөөс эхлэн 12 сар үргэлжилнэ. Үйлдвэрлэгчээс олгосон урт хугацааны баталгааны хугацаа нь худалдан авагчид өөрчлөлтгүйгээр олгогдох ёстой.

- Ашиглалтын болон засвар үйлчилгээний дараах гарын авлагыг англи, монгол хэл дээр дагалдуулж өгөх

ХЯНАСАН:

СҮХБААТАР ДЭВШИЛ ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АМГАЛАН

ХЯНАСАН:

СҮХБААТАР ДЭВШИЛ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА Ц.БАЯРЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

СҮХБААТАР ДЭВШИЛ ОНӨААТҮГ-ЫН
ИНЖЕНЕР, ХЯНАЛТ, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АХЛАХ
АЖИЛТАН М.ЦЭВЭЭН-ОЧИР